

АКАДЕМИЧ Н.СОДНОМЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Академич Намсрайн Содномын нэрэмжит тэтгэлэг (цаашид нэрэмжит тэтгэлэг гэнэ) олгох нь дараах үндсэн хоёр зорилготой. Үүнд:

- 1.1. Монгол Улсад цөмийн физик, технологийн судалгааны салбарыг үндэслэгчдийн нэг, Монгол Улсын физик математикийн ухааны анхны эрдэмтэн, Гавьяат багш, академич, профессор Намсрайн Содномын алдрыг мөнхжүүлэх;
- 1.2. МУИС-д цөмийн физик, технологийн чиглэлээр суралцаж буй докторантыг болон 35 хүртэлх насны судлаач ажилтныг дэмжих.

Хоёр. Нэрэмжит тэтгэлэг олгох нөхцөл

Дараах нөхцөлийг хангасан судлаач ажилтан эсвэл докторант суралцагчид нэрэмжит тэтгэлгийг олгоно. Үүнд:

- 2.1. Монгол Улсын цөмийн физик, технологийн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа;
- 2.2. МУИС-д цөмийн физик, технологийн чиглэлээр суралцаж буй докторант эсвэл 35 хүртэлх насны судлаач ажилтан байх;
- 2.3. Судалгаа шинжилгээний ажлын үр дүн нь олон улсын болон дотоодын мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдсэн эсвэл үйлдвэрлэл, практикт шилжсэн, зохиогчийн эрхийн гэрчилгээ, лиценц авсан; арга, аргачлал, стандарт батлуулсан; цөмийн физик, технологийн чиглэлээр болон тус чиглэлтэй холбоотой судалгаа шинжилгээний ажил хийж буй (үүнд нь: байгалийн ухааны судалгаанаас гадна уг чиглэлтэй холбоотой нийгэм, эдийн засгийн судалгаа байж болно); диссертацаа хамгаалахад бэлэн болгосон зэрэг бол эн түрүүнд сайшаагдана.

Гурав. Бүрдүүлэх материал

- 3.1 Маягтын дагуу бөглөсөн нэрэмжит тэтгэлэгт хамрагдах хүсэлт /1 хувь/;
- 3.2 Ажил байдлын тодорхойлолт /1 хувь/;
- 3.3 Докторант суралцагч бол дүнгийн мэдээлэл буюу дүнгийн тодорхойлолтын эх хувь /1 хувь/;

3.4 Хэвлүүлсэн бүтээлийн жагсаалт (байгууллагынхаа эрх бүхий этгээдээр баталгаажуулна) /1 хувь/;

3.5 Иргэний үнэмлэхний хуулбар /1 хувь/;

Дөрөв. Нэрэмжит тэтгэлэг олголт

4.1. Нэрэмжит тэтгэлгийг зарлах, хамрагдах хүсэлтэй магистрант, докторантын материалыг хүлээн авах, цугласан материалыг төвийн захиргаанд ирүүлэх, сонгон шалгаруулалт хийх, батламж, мөнгөн тэтгэлгийг олгох зэрэг үйл ажиллагааг тухайн хичээлийн жилийн намрын улиралд багтаан хэрэгжүүлж дуусгасан байна.

4.2. Нэрэмжит тэтгэлгийн зарлал, сурталчилгааг төвийн болон МУИС-ийн цахим хуудсаар, мөн анонс хэлбэрээр түгээнэ. Тэтгэлгийн материалыг хүлээн авах хугацаа багадаа 14 хоног байна.

4.3. Нэрэмжит тэтгэлэг олгох асуудлыг төвийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, захирлын тушаалаар баталгаажуулна.

4.4. Нэрэмжит тэтгэлгийг тухайн хичээлийн жилд амжилтаараа тэргүүлсэн шилдэг докторантад эсвэл 35 хүртэлх насны судлаач ажилтанд олгоно.

4.5. Нэрэмжит тэтгэлгийн нийт хэмжээ 1,000,000 төгрөг хүртэл байна.

----oO-----



Цөмийн физикийн судалгааны төвийн
Захирлын 2020 оны 12 дугаар сарын 18-ний
өдрийн А/09 тоот тушаалын 1.1-р хавсралт

АКАДЕМИЧ Н.СОДНОМЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МАЯГТ*

/Судлаач ажилтан болон докторантад зориулсан/

Үндсэн мэдээлэл

1. Эцэг /эх/-ийн нэр: _____ Өөрийн нэр: _____
Ургийн овог: _____ Төрсөн он сар өдөр: _____
Хүйс: ____ Үндэс угсаа: _____
2. Регистрийн дугаар: _____
3. Төрсөн аймаг, хот: _____
4. Оршин суугаа хаяг: _____
5. Холбоо барих утас: 1. _____ 2. _____
6. Цахим шуудангийн хаяг: _____
7. Суралцаж буй докторын хөтөлбөр: _____
8. Судалсан багц цаг: _____
9. Голч оноо ба голч дүн: _____
10. Ажил эрхэлдэг бол Байгууллагын бүтэн нэр: _____ хашиж буй албан тушаалын нэр:
_____ ажилласан хугацаа (жил): _____
11. Харилцагч банкны нэр: _____
Дансны нэр: _____ Дансны дугаар: _____
12. Гавьяа, шагнал, ажлын амжилт, тэтгэлгийн мэдээлэл
/Харьяа яам, дээд байгууллага болон одоо ажиллаж буй байгууллагын баярын бичиг, өргөмжлөл гэх мэт
шагнал, тэтгэлгийн талаар бичнэ/

Сүүлийн 6 сарын дотор
авахуулсан цээж зураг

д/д	Төрөл	нэр	Тайлбар

Маягтыг үнэн зөв бөглөсөн: /...../

Гарын үсэг

Гарын үсгийн тайлал

20 ... оны ... сар ... өдөр

* Маягтыг заавал компьютерээр бөглөнө. Бөглөж өгсөн маягт дахь мэдээллийг зөвхөн энэхүү тэтгэлгийн сонгон шалгаруулалтын зорилгоор хэрэглэнэ.